

Орон Бүхний прагматик нар нэгдэгтүн! АНХ ОУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 66 (2370)

1974 оны 9 дүгээр сарын 5

ПҮРЭВ

Ургац хураалт

Тус аймгийн САА, ТАА, ХАА-н нэгдлүүд 1974 онд үр тариа 109,4 мянга, төмс 16,1 мянга, хүнсний ногоо 15,7 мянга, малын тариагаар тэжээл 58,7 мянган тоныг тус тус хураан авч, улсад үр тариа 76,6 мянган тонн, үүнээс буудай 54,7 мянга, төмс 10,2 мянга, хүнсний ногоо 15,4 мянган тоныг туснах болно.

Дээрх зорилтыг биелүүлэхэд тариа ногоог богино хугацаанд хаягдалгүй хураах явдал чухал юм.

Энэ оны ургац хураалтанд аймгийн хэмжээгээр үр тарианы комбайн 393, дарсны комбайн 34, төмсний комбайн 58 ажиллаж үр тариаг ажлын 20 хоногт, төмсийг 10 хоногт багтаан дугсах боломжтой байна.

Энэ оны ургац хураалтын ажлыг Жаргалант, Борнуур, Угтаалын САА, Архустын ТАА, Өндөрширээт, Баяндалгэрийн нэгдлүүд аж ахуй зохион байгуулалтын бэлтгэл сайтай эхлэж байна.

Одоогоор Жаргалант, Угтаалын САА, Эрдэнэсантайн ТАА ангилан хадалтаандаа 6 усад нэгдэл, САА-нуудаас гүүрүн орж 3—12000 га үр тариаг ангилаад байна.

Үр тарианы ургамлуудыг хаягдалгүй хураан авхын тулд ургац хураалтанд ажиллаж байгаа комбайн бүрт тариа хадах, цайруулах, цэвэрлэх дамжлагуудыг зөв завсарт хаалт чигжээ хийж үтрэм талбайн хооронд бусад зохих авто машины тэвнийг өндөрлөг, шалны зөв завсарыг чигжсэн байх шаардлагатай.

Мөн тариа тэвэрлэх зам гүүрийг завсарлан барилттай газруудад замын тэмдгүүдийг тавих, үтрэмийн талбайн гадаргууг тэгн цэвэр хуурай байлгах, үр цэвэрлэгч машины тохируулгыг тарианы чийг, үрийн хэмжээ чанар, хог ургамлын хольц хир зэрэг байгаад анхаарч талбай бүрийн ургацын байдалд тохируулан оорчиж байх нь тарианы хаягдлыг багасгах нөхцөлийг бүрдүүлнэ.

Ангилан хадалтанд ажиллаж байгаа комбайнчид нь тарианы болцын байдал, ондрийн хэмжээ нягт сийргийг харгалзан мотомлын байрлал, эргэлт хадалтын ондрийг зөв тохируулан ажиллавал талбайд түрүүтэй тариа хаягдалгүйг анхаарах хэрэгтэй.

Энэ жилийн хур бороо ихтэй байгаа онцлог нөхцөлд үр тариаг ангилан хадахад хадалтын ондрийг 10—12 см-ээс хэтрүүлэлгүйг байлгахар жатныг тохируулбал хадалт цайруулалтын хоорондох хугацааг багасгах боломжтойг анхаарах нь зүйтэй.

Ургац хураалтын чанарт тавих хяналтыг сайжруулж нэлсэн ба намхан тариан хураах технологиор комбайнуудыг тоноглож ажилдуулах, морсон баллыг эргүүлэх аргачлалыг нийт САА, ТАА-нууд оргон хэрэглэхийн гадна ургац хураалтанд мордох социалист уралдааны болзлыг 3, 5, 7 хоногоор гарган бүх хүмүүсийг хамруулан заавал дүгнэж ажиллавал зохино.

Тариа ногооны ургацыг хаягдалгүй хураан авахад нам, улс, олон нийтийн байгууллага удирдлага зохион байгуулалтаар сайн хангаж хяналт шалгалтыг комбайн, авто машин үтрэмийн талбайд, төмөногооны бүт нэг бүрт явуулж чадсанаар ургацыг хаягдалгүй авч төлөвлөгөөг давуулан биелүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

АЖЛЫН ДОЛОО ХОНОГТ

Жаргалантын САА-н хамт олон 1974 оны ургац хураалтын ажилдаа эхлэн ороод ажлын 7 хоногт 12630 га ангилан хадаж, 503 га-гийн үр тариа цайруулж, 133 га-гийн төмс, хүнсний ногооны ургац хурааж улсад 540 тонн төмс, 174 тонн хүнсний ногоо тушааж төмс, хүнсний ногооны эрт ургацын төлөвлөгөөг 111,8—134 хувиар биелүүлэв.

Тариа хураалтын ажил

комбайнч С.Мягмар, Ц.Бор, Б.Тогтохсүрэн нарын 23 комбайнч эхний 8 хоногийн төлөвлөгөөг 101-ээс дээш хувиар биелүүлж шагналт цалин авсаны дээр тасаг бригадын дотроос Чунагдорж даргатай төвийн тасаг, Дамбадаржаа даргатай төмсний бригад, Пүрэвдорж даргатай хүнсний ногооны бригад 7 хоногийн уралдаанд тэргүүн байр эзлэв.

Ш. ЯДАМСҮРЭН

Хадланчдын амжилт

Борнуурын САА-н 3 дугаар бригадын хамт олон энэ жилийн хадланд бэлтгэл, зохион байгуулалт сайтай гарч ажилласны дүнд ажлын 28 хоногт 290 тонн өвс хадаж төлөвлөгөөгөө 103 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

Одоо тус бригадынхан хадсан өвснийхөө 60 хувийг өвөлжөөндөө татаад байна.

Д. ДАШЦЭРЭН

Заамар сумын 8 жилийн дунд сургуулийн хэсэг багш, ажилчид хадлангийн нэг бригад болон гарч гар халуураар 4 өдөрт 50 тонн өвс хадаж нэгдэлдээ хүлээлгэн өгөв.

Ш. БЯМБАА

Хадлангийн явц

Аймгийн хэмжээгээр 9 дүгээр сарын 1-ний байдлаар 64,0 мянган тонн өвс бэлтгэж төлөвлөгөөний 66,9 хувийг биелүүлээд байгаагийн дотроос САА 79,3, ХАА-н нэгдлүүд 65,6, ТАА-нууд 32,9 хувьтай байна.

Хадлангийн төлөвлөгөөний биелэлтийг сумдаар байр эзлүүлэн үзүүлбэл:

Сумд	хувь	байр
Жаргалант	102,6	1
Баян-өнжүүл	102,0	2
Баянцагаан	92,5	3
Лүн	84,5	4
Заамар	79,9	5
Өндөрширээт	79,4	6
Угтаал	73,7	7
Баясүмбэр	72,2	8
Бүрэн	70,9	9
Баянцогт	69,6	10
Борнуур	69,5	11
Мөнгөнморьт	69,1	12
Дэлгэрхаан	64,7	13
Алтанбулаг	61,8	14
Баянзүрх	58,4	15
Эрдэнэсант	56,8	16
Сэргэлэн	50,4	17
Баян	44,5	18
Баяндэлгэр	33,5	19
Эрдэнэ	32,3	20
Баянжаргалан	14,7	21

Баянжаргалан, Баянцагаан сумд мэдээгээ графикт хугацаанд нь ирүүлээгүй учир хуучнаар нь авч гаргав.

Статистикийн товчоо

Жаргалант сумын Намын хорооны нарийн бичгийн дарга Н.Дашням, сум-САА-н дарга Д.Аръяа нарт

Энэ оны хадлангийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө 2,6 хувиар давуулан биелүүлсэн явдалд танай сумын нам, улс, олон нийт, ХАА-н байгууллага, нийт ажилчдад халуун баяр хүргэж энэ оны төлөвлөгөөт ургац хураалт бусад ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа итгэж байна.

Баян-Өнжүүл сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Д.Жамбал- дорж, сум-нэгдлийн дарга Х.Дорж нарт

Энэ оны хадлангийн төлөвлөгөөг 2 хувиар хугацаанаас нь өмнө давуулан биелүүлсэн явдалд танай сумын нам, улс, хөдөө аж ахуйн байгууллага, сумын нийт хөдөлмөрчдөд халуун баяр хүргэж улс ардын аж ахуйн төлөвлөгөөт бусад ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа итгэж байна.

Мөнгөнморьт сумын намын хорооны нарийн бичгийн дарга Г.Жамбал, сум-нэгдлийн дарга Д.Сүндуй нарт

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж 1974 онд улсад тушаах сүүний төлөвлөгөөг 3,7 хувиар давуулан биелүүлсэн явдалд танай сумын нам, улс, хөдөө аж ахуйн байгууллага, нийт хөдөлмөрчдөд халуун баяр хүргэж улс ардын аж ахуйн төлөвлөгөөт бусад ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа итгэж байна.

Аймгийн Намын хорооны
нэгдүгээр нарийн бичгийн
дарга Ц.АДЪЯА

Аймгийн АДХ-ын
гүйцэтгэх захиргааны
дарга Ч.ДАШДЭМБЭРЭЛ

Хашаа барилт, худаг гаргалтын явц

Аймгийн хэмжээгээр 9 дүгээр сарын 2-ны байдлаар хашаа барилт 70,6, өрөмдмөл худаг гаргалт 50,0, улсын хүчээр гаргах уурхайн худаг 71,4, орон нутгийн хүчээр гаргах уурхайн худаг 61,0 хувийн амжилттай байна.

Төлөвлөгөөний биелэлтийг сумдаар үзүүлбэл: (хувиар)

Ашигла- танд өг- сөн хашаа	Ашигла- танд өг- сөн уур- хайн ху- даг
Алтанбулаг	58,0
Батсүмбэр	66,6
Баян	42,9
Баян-өнжүүл	100,0
Баяндэлгэр	0
Баянжаргалан	100,0
Баянзүрх	100,0
Баянцагаан	100,0
Баянцогт	100,0
Борнуур	100,0
Бүрэн	28,6
Дэлгэрхаан	60,0
Жаргалант	50,0
Заамар	0
Лүн	67,0
Мөнгөнморьт	100,0
Өндөрширээт	71,4
Сэргэлэн	100,0
Угтаал	66,6
Эрдэнэ	50,0
Эрдэнэсант	100,0
Баянчандмань	66,6
Зуунмод	—

Статистикийн товчоо

ОТРЫН ОЛЗ

10 гаруй жил үхэр мал лаг арвин туршлагатай болсон Р. Гарам гуайг Лүнгийнхэн андахгүй. Хашир малчныг Өргөн намын сэлүүн сайхан хөндийд зуны отор хийж явахад нь уулзлаа.

Туул голын хөвөөнд хөндөрлөгийг арлан бэлчиж яваа үхэр сүрэг малч эзнийхээ хариулгаар үдийн халууныг сэрүүвтэр бэлчээрт идэшлэн өнгөрөөж, буй нь энэ ажээ.

Гарам гуай ном уншиж суунгаа үхрийнхээ аясыг харж: Зуны цагт үхрийг

аль болохоор тэнүүн, ус сайтай, цэцгэрхэг ургамалтай бэлчээрт бэлчээх сайн байдаг.

Үхрийг өглөө эрт бэлчээж урсгал цэнгэг усанд услах нь сайн юм.

Би сүүлийн 5 жил дараалан сувай үхэр хариулж байна.

Манай нутгийн Улаан худаг, Өргөн намаг, Ятуу тын хөндий бол хавар, намар, зуны оторт үхэрт маш их зохимжтой.

Өвөл Толийн нуруунд өвөлждөг.

Жил бүр 280—330 үхэр хариуцан малладаг.

Одоо үхэр сүрэг маань овоо таргалж байна.

Энэ ч отрын олз гэж Гарам гуай ярих. 1974 онд эр үхэр нь дунджаар 589—601, гуна, гунж 260—310 кг жин татжээ.

Хөөврийн төлөвлөгөөг жил тутам 100,4—103,4 хувиар биелүүлсэн аж.

Ийнхүү отор нүүдлийг амжилттай хийж байгаа туршлагатай малчин Гарам гуай үхрийнхээ бэлчээрийг даган нүүдэллэж явна.

Л. БАТСУХ

М. ДАШ-ЯНЖИВ

ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧ



Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн саальчин, МАХН-ын гишүүн Ц. Цэрэннадмид V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 5 сарын өмнө биелүүлж хамт олшоо үлгэрлэн ажиллаж байна.

Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг

БОЛЗОЛ ХАНГАХААР...

Баянцогтын САА-н трактор комбайнчид МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, атрын 15 жилийн ой угтаж аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооноос 1974 оны ургац хураалтанд амжилт гаргасан САА, ТАА, ХАА-н нэгдэл, тэргүүний трактор комбайнчдыг шалгаруулах уралдааны болзлыг биелүүлэхээр шамдан ажиллаж байна.

Тус САА-нхан одоогийн байдлаар 7000 га-д уринш хагалгаа хийгээд байгаа ба үлдэх 800-гаг цэвдэгшээр нөхөн гүй-

цээх бөгөөд Гуна, Сарлаг толгойн тасгийн 1, 2 дугаар бригадууд бусад тасаг, бригадуудаас хамгийн түрүүнд уриншийн төлөвлөгөөг биелүүллээ.

Тус САА-н Цэрэндаш даргатай Гунын тасгийн 1 дүгээр бригад энэ жилийн тариа хураалтаар улсын аварга бригад болох үүрэг авсаны дотор трактор комбайнч Чулуунбаатар, Буденин, Д.Очир, Шийтэр нар улсын хошой аварга комбайнчны болзол хангах үүрэг аваад урам зоригтой ажиллаж байна.

МАНЯЙ СУРВАЛЖЛАГЧ

18000 ЛИТРЭЭР

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн Дамдин даргатай саалийн ферм өнөө жил 251800 литр сүү улсад тушаах төлөвлөгөөгөө 8 дугаар сард 18000 литр сүүгээр давуулан биелүүлж бахдам амжилт гаргав.

Саальчин Сүрэн, Чинбат, Цэрэннадмид, Жамбал, Цэнгээ нар 7 дугаар сард, илгээлтийн эзэн саальчин Ургамал, Лхагва сүрэн, ахмад саальчин Дарь нар 8 дугаар сард жилийнхээ төлөвлөгөөг биелүүлж уралдаанд бусад саальчдаа хошуучилж явна.

Е. БАНЗРАГЧ

ХӨӨРӨГИЙН ЭНГЭРТ

Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн «Эрдэнэ-уул» бригадын саальчид даалгаварт өвсөө шин тэжээлтэй үед нь бэлтгэж базаахаар чармайж Хөөрөгийн хойт энгэрийн ам бүрт бухал арайлгаж нуруу дунхийлгэж байна.

Мухарын хаваржааны урд хөтөл дээр гарч очиход тэртэй хоолойд хадланчдын хадуур наранд гялалзах нь биднийг дадлах шиг.

Хүрч очвол хэдэн хүүхэн өвс хадаж, хүүхдүүд өвс өргүүлж харагдана.

Эд нар бол «Эрдэнэ уул» бригадын Ганжуур

ахлагчтай суурийн саальчид байлаа.

Хадуур хурц, хадлан их үү? гэсэн чинь манайхан шуугиулаад өгдөг хүмүүсээ.

Цэцгээ, Нина, Отгон гээд л хадлан сайн хаддаг хүүхнүүд бий.

Нараа охин, Цогтсайхан, Цэцэгмаа гээд өвс сайн бухалддаг хүүхдүүд ч бий.

Бид 4 тонн өвсний даалгавартай, хоёр саамын хооронд 3 өдөр яваад 43 бухалтай болоод байна гэж үхэрчин өвгөн Гомболам гуай ярих.

Д. ОТГОН

СҮҮ, ТОС БЭЛТГЭЛТИЙН ЯВЦ

Аймгийн хэмжээгээр 8 дугаар сарын 30-ны байдлаар улсад тушаах сүүний төлөвлөгөөний 68,5 хувийг гүйцэтгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,2 хувиар дээгүүр байна. Баянчандмань, Мөнгөнморьт, Заамар сумд улсад тушаах сүүнийхээ төлөвлөгөөг, Дэлгэрхаан сум тос эзлэмэрийн төлөвлөгөөг биелүүлээд байна. Эзлэмцэр, тос үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт 66,8—70,0 хувьтай байна.

Сүү тушаалт, тос, эзлэмцэр үйлдвэрлэлтийн явцыг сумлаар үзүүлбэл: (хувиар)

	улсад тушаах		Үйлдвэрлэлт		улсад тушаах		Үйлдвэрлэлт	
	сүү	тос	сүү	тос	сүү	тос	сүү	тос
Алтанбулаг	78,3		Бүрэн	81,9	78,9	36,5		
Батсүмбэр	85,0		Дэлгэрхаан	89,4	112,6	102,4		
Баян	46,0		Заамар	108,0				
Баян-Өнжүүл	71,4	81,5	Лүн	39,0				
Баяндэлгэр	65,3	69,6	Мөнгөнморьт	103,7				
Баянжаргалан	35,1		Өндөрширээт	38,0				
Баянзүрх	62,5		Сэргэлэн	47,3				
Баянцагаан	68,3	67,6	Эрдэнэ	73,5				
Баянцогт	32,1	8,1	Эрдэнэсант	72,9	47,8	82,6		
Борнуур	76,9		Баянчандмань	44,4				

СТАТИСТИКИЙН ТОВЧОО

ЦЭВДЭГШ ХАГАЛГАА

Улсын тэргүүний тариаланчдын зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэн атар газар эзэмшсэний 15 жилийн ой угтсан хөдөлмөрийн ээлжинд манай тариаланчид ургац хураалт, уринш боловсруулалт, цэвдэгш хагалгааг зохих хугацаанд нь бүрэн хийж дуусгах өндөр хариуцлага хүлээж байна.

Тариаланчдын намын ажлын чухал хэсэг цэвдэгш хагалгааг цаг алдалгүй чанартай хийхийн тулд анхны талбай сулармагц техник, хүн хүчийг сайтар зохион байгуулан эхлэх ёстой.

Өнөө жил тарианы болц

эрт гүйцэж, ургац хураалтын ажил өнгөрсөн оныхтой харьцангуй эрт эхэлсэн нь цэвдэгш хагалгааг урьд оноос яаравчлан эхлэж төлөвлөгөөт талбайгаа бүрэн хагалах боломж өгч байна.

Энэ оны цэвдэгш хагалгаагаар САА, 22 мянган га, ТАА 5,5 мянган га, ХАА-н нэгдлүүд 3,4 мянган га, аймгийн дүнгээр 30,9 мянган га талбайг хагалах төлөвлөгөөтэйгээ гадна уринш хагалгаанаас дутуу үлдсэн 4363 га-г цэвдэгшээр нөхөн хагална.

САА, ТАА, ХАА-н нэгдлүүдийн өмнө цэв-

дэгшээр хагалах талбайн хэмжээ нэмэгдэж байгаатай уялдаж энэ ажлыг эртнээс бэлтгэл, зохион байгуулалт сайтайгаар эхлэх шаардлага тавигдаж байна.

Үүний тулд САА, ТАА, ХАА-н нэгдлүүд ургац хураалтаар түрүүн дууссан талбайн сүрэл татах, боох, цэвдэгш хагалгаа хийх хэзэрийн бригадуудыг яаравчлан гаргаж цаг хожиг цэвдэгш хагалгааг эхэлбэл зохино.

Цэвдэгш хагалгаа нь ургац хураалтын ажилтай давхцан энэ ажилд тавих анхаарал суларснаас төлөвлөгөө тасрах, улмаар ирэх оны тариалалтын ажлыг хүндрүүлж

ургацын хэмжээнд нөлөөлж байсан өмнөх жилүүдийн байдалд дүгнэлт хийж цэвдэгш хагалгаанд тавих хяналт шалгалтыг судруулж болохгүй.

Цэвдэгш хагалгаанд шаардагдах агрегатүүдийг сайн бэлтгэлтэйгээр нарийн хуваарилж агрегат бүрийг ээлжийн жолоочтой болговол зохино.

Түүнчлэн хүн хүч, шатахуун, хоол, хүнс, орон байрыг хангалттай бэлтгэж цэвдэгш хагалгаа, сүрэл таталтын үеийн социалист уралдааныг олон хэлбэрээр өрнүүлэн ойр ойрхон дүгнэн сурталчилж хүмүүсийн идэвх хөдөлгөөнийг өрнүүлэхэд ХАА-н болон нам, олон

нийтийн байгууллагууд онцлон анхаарах хэрэгтэй.

Цэвдэгш хагалгааны үед талбайн соёлжилт хагалгааны чанарт САА, ТАА, ХАА-н мэргэжилтнүүд болон сумын ардын хянан шалгах хороо, группүүд шалгалтыг байнга хийж боловсруулдаг талбайг агрегат бүрээс хүлээн авбал зохино.

Цэвдэгш хагалгааг агро техникийн шаардлагын дагуу чанартай хийж ирэх оны өндөр ургац авах нөхцлийг бүрдүүлэхэд нийт тариаланчид, ХАА-н байгууллага бүр онцгой анхаарч ажиллахаа.

ХААУ газрын агрономич Б. БАРХУУ

Улсын тэргүүний багш нарын зөвлөлгөөний огно

ЗӨВЛӨЛГӨӨН УГТСАН АЖЛААС

(Дугуй ширээний яриа)

1975 онд болох улсын болон аймгийн тэргүүний багш нарын зөвлөлгөөнийг угтаж зохиож байгаа ажлын талаар зарим сургуулийн захирал, эрхлэгчид тэй үүлээж яригдсан ярицлагыг дор нийтлэв.

АСУУЛТ—Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх талаар ямар ажил зохиож байна?

ХАРИУЛТ—А.Авирмид (Батсүмбэрийн САА-н дунд сургуулийн захирал)

—Багш нарын дунд орос хэлний дугуйлан байгуулан 7 хоногт 2 удаа хичээллүүлж байна.

Хэвлэл ашиглах болон хууль эрхийн мэдлэгийг улиралд нэг удаа багш нараас тогтмол шалгадаг заншилтай болсон.

Багш нар улс төрийн сургуульд 100 хувь хамрагдан суралцаж байна.

Өөрийн мэргэжил боловсролыг хэрхэн дээшлүүлж байгаа тухай сонголыг багш нараар бэлтгүүлэн захирлын дэргэд

дэх зөвлөлөөр хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгдөг.

АСУУЛТ—Сургалтанд гарч байгаа тэргүүн туршлагыг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

ХАРИУЛТ—С.Баярхүү (Баяндэлгэр сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч)

—Манай сургуулийн хамт олон 1973—1974 оны хичээлийн жилийг тэргүүн туршлага эзэмшиж он болгон тодорхой ажлууд зохион явуулаа.

ЗСВНХОУ-ын Курган мужийн багш нарын мэргэжил дээшлүүлэх институттай харилцаатай ажиллаж сургалт хүмүүжлийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй удирддаг аргыг сургуулийн захиргаа өөрийн ажилдаа удирдлага болгон хэрэглэж байна.

Мөн Москва хотын 706 дугаар сургуулийн тэргүүний багш нарын хичээлийн үр дүнг дээшлүүлж анги улируулахгүй сургадаг аргыг багш Баасан, Цэрэнханд, Мөнгөнцэцэг, Буджав нар өөрсдийн ажилдаа бүтээлчээр хэрэглэсний үр дүнд

удирдсан анги болон заадаг хичээлдээ сурагчдыг 100 хувь сургаалаа.

Багш Гантулга, Цэрэнханд, Мөнгөнцэцэг нарын туршлага аймгийн нийт багш нарын заавал эзэмших туршлага болон хэвлэлдээ гараад байна.

АСУУЛТ—Сургуулийнхаа элсэлт цугларалтын төлөвлөгөөг хэрхэн биелүүлэв?

ХАРИУЛТ—Чимидрэгзэн (Заамар сумын дунд сургуулийн захирал)

—Манай сургууль сурагчдын элсэлт цугларалтын төлөвлөгөөг сүүлийн 5 жилд 100,1—101,2 хувь дотуур байранд суугчдын төлөвлөгөөг 110—124 хувь биелүүлж, бүх сурагчдын 83,6 хувийг дотуур байраар хангаад байна.

Манай сургуульд Чимиддорж, Халзан, Цэрэнноров, Сүхбаатар нарын зэрэг нэгч сурагчийг сургууль завсардуулалгүй сургадаг багш нар олон бий.

АСУУЛТ—Сурлагаар хоцрогсодтой хэрхэн ажиллаж байгаа талаар ярьж

өгнө үү?

ХАРИУЛТ—Гончигсүрэн (Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургуулийн захирал)

—Сурагчдын сурлагаар хоцрогдох явдал бага ангид нилээд байгааг харгалзан сургуулийн захиргаанаас жил бүр сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргын нэрэмжит шалгалтыг 1—3 дугаар ангид тогтмол явуулдаг боллоо. Уг шалгалтын мөрөөр сурлагаар хоцрогдон жил дараалан анги улирч байсан 20 шахам сурагчийг нэг анги болгон Ардын гэгээрлийн тэргүүний ажилтан, багш Э. Жүрмэддоржид хариуцуулан ажиллуулсан нь үр дүнг өгч сурагчдын 60 хувь нь 3 дугаар ангийн программыг амжилттай биелүүлж анги дэвшсэн.

Сургуулийн захиргаа онц сурлагатан сурагчдын зөвлөлгөөнийг жил бүр тогтмол хийж сурлагаар хоцрогсод туслах хэсэг байгуулан ажиллуулж үр дүнд хүрч байна.

АСУУЛТ—Сургуулийн дэргэдэх эвлэл, пионерийн ажлын талаар ярьж өгнө үү?

ХАРИУЛТ Ганболд (Алтанбулаг сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч)

—Пионер сурагчдын дунд зохиох ажлыг сурагчдын нас биеийн онцлогт тохируулан ахлах, дунд, бага насны болон баатарчуудын бүлгийн нэгдэл гэж 4 хэсэгт зохион байгуулан явуулдаг.

Өнгөрсөн хичээлийн жилийн 2 дугаар хагасаас эхлэн пионерийн ажлыг бэлтгэл ажил, жинхэнэ ажлын үе гэж 2 хуваагаад уг ажлыг сард 2 удаа зохиох болсон нь пионерийн ажил цуглааныг хүмүүжлийн сургууль болгоход их ач холбогдолтой болж байна.

МПБ-ын 50 жилийн ойг угтаж сурлага хүмүүжлээ дээшлүүлэх 2 жилийн төлөвлөгөөг дунд ангийн сурагч бүр хийж хичээл хүмүүжлийнхээ ажилд тооцоотой хандаж сурч байна. Сургуулийн захиргаанаас сэдэвт ажлын уралдааныг анги бүлгүүдийн хооронд тогтмол явуулж байна.

Л а и г тэмдэглэсэн
м а н а й сурвалжаах
идэвхтэн
Ч. ДОРЖГОЧОО

СУРГАЛТЫН ШИНЭ СИСТЕМ ЭЦЭГ, ЭХИЙН ҮҮРЭГ

Зарим эцэг эх, багш нар хүүхдэд хичээлийн сэдэв бүрийг тайлбарлаж өгөхгүй байна гэх буюу хүүхдэд даалгавраа хийж чаддаггүй байвал бодлого нь бодоод өгчих, өөрөө мэдэхгүй бол мэддэг хүнээр бодуулчих зэрэг зохицсгүй байдал үзэгддэг.

Энэ бол шинэ системээр хичээллэж байгаа одоо үеийн сургалтын аргатай тохирохгүй зүйл.

Шинэ материалыг багш голлон хэлж өгдөг байсан арга нь тухайн үедээ дэвшилттэй байсан боловч орчин үеийн шинжлэх ухаан техникийн үрсэнгүй хөгжилтөөс шалтгаалж сургалтын шинэ арга хэлбэр гарч ирлээ.

Сургалтын гол онцлог нь мэдлэг эзэмших ажиллагаанд хүүхдийг аль болохоор бүрэн дүүрэн оролцуулж, гол дүрэм, тодорхойлолтыг өөрсдөөр нь гаргуулан шинжлэх ухаанд дурлах сонирхлыг төрүүлэхүйцээр хичээлийг зааж байгаад оршино.

Иймээс эцэг эхчүүд хүүхдийнхээ гэрийн даалгаврыг удирдахдаа уг бодлогыг яаж бодохыг хүүхдээр өөрөөр нь эрэл хайгуур хийлгэн олуулж дараа нь ямар аргаар бодох аргаа гаргаж ирдэг болгоход анхаарч ажиллавал зохино.

Ингэж чадвал багш эцэг, эхийн шаардлага нэгдмэл болж үр дүн нь дээшлэх болно.

Шинэ программаар хичээллэхэд сурагчдад бэрхшээл тохиолдох нь мэдээж. Харин бэрхшээлийг даван туулахад нь эцэг, эхчүүд туслах ёстой.

Эцэг, эхээс хүүхдэд үзүүлэх тусламж нь уг зүйлийг шууд хэлж өгч хүүхдийнхээ орноос төлөөлөн сэтгэх, хийхэд биш яаж гүйцэтгэх арга замыг зааж өгөх, өөрсдөө үүнийг хийх бололцоогүй бол мэдэх хүмүүстэй уулзуулах ба холбогдох материал бэлтгэж өгөх нь зүйтэй. Ер нь эцэг эх хүүхдийнхээ сурлага хүмүүжлийг байнга анхаарч багш нартай нь тогтмол уулзаж чухам ямар хичээлд хоцорч, ямар бэрхшээлтэй учирч байгааг нь мэддэгд түгдн яаж туслах вэ гэдгийг нарийвчлан бодож уг ажлыг зохион байгуулдаг байх хэрэгтэй.

Бололцоотой цагтаа хүүхдийнхээ хичээлд сууж хичээлд оролцож байгаа идэвхи, бие дааж ажиллах чадвар зэрэгтэй танилцахын зэрэгцээгээр багшийн заах аргыг биеллэн үзэж байх нь зүйтэй.

Ер нь хүүхдийн оюуны өндөр хөгжлийг хангаж чадвал цаашид амжилттай суралцах нөхцөл болох учраас бие даан ажиллуулах аргыг нилээд хугацаагаар уйгагүй хэрэглэж хөдөлмөрсний үр дүнд сая мэдлэг эзэмших чадвар бий болж эцэг эхийн ажиллагааг хөнгөвчлөх болно.

Хүүхдийг бие даан

ажиллуулахдаа жижиг зүйл гэлгүй хэвшүүлэх шаардлагатай.

Хүүхдийг ямарч ажилд оролцуулахдаа эцэг эх ерөнхийд нь удирдаж харин өөрсдөөр нь уг ажлыг хэрхэн хийх арга дэс дараалал зэргийг нь бодуулж сэтгүүлж тэдний оюун бодлыг дайчилж байх нь зүйтэй.

Эрүүл биед саруул ухаан оршино гэсэн ардын цэцэн үгийг санаж хүүхдийн хээ эрүүл мэндэд ямагт санаа тавин эрүүл ахуйн дэглэм журмыг нарийн сахиж байх нь сургалтын шинэ системээр хичээллэж байгаа одоо үед чухал зүйл юм.

Иймээс сурагчдын өдрийн дэглэмийг ангийн багштай хамтран зөв зохион байгуулж түүнийг эгштал баримтлуулж сургах талаар, гойд анхаараж хэрэгтэй.

Ингэснээр сурагчид цагийн хуваарийн дагуу тогтмол хичээллэж, хооллох, амрах бөгөөд энэ нь амжилттай суралцахын нэг чухал үндэс болно.

Хүүхдийг үзвэр үзүүлэх явдал ач холбогдолтой боловч кино, жүжиг сард 2-оос илүү үзэх шаардлагагүй. Ер нь сургалтын шинэ системд шилжиж сургалтын арга өөр болсон өнөө үед хүүхдийг хүмүүжүүлэх арга барилдаа улам боловсронгуй болгох явдал нэн чухал болж байна.

Ш. МӨНХБАТ

ГАВШГАЙЧ БРИГАД

Сэргэдэн сумын «Авдархангай» нэгдлийн Хөшгийг бригадын малчин залуучууд «Залуучуудын гавшгайч» бригад байгуулж 2 жилийн хугацаатай үүрэг авлаа.

Тус бригадын МХЗЭ-ийн гишүүд, залуучууд малын зүй бус хорогдлыг багасгах, төл бүрийг бүрэн бойжуулах, үйлдвэрлэлийн даалгавраар тавигдсан төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг биелүүлэх, нэг-

дэлдээ 500—1000 төгрөгийн цэвэр ашиг оруулахаас гадна БНАМУ-ын хөдөлмөрийн баатар А. Авирмэдийн туршлага зоо-мал эмнэлгийн мэдэгдэхүүн эзэмших, боловсролоор шат ахих, бригадын концерттой болж, суурьт хөтлөгдөх анхан шатны бүртгэлийг бүрэн хөтлөх зэргээр 20 гаруй төрлийн үүрэг аваад ажиллаж байна.

Ч. САНГИРАГЧАА

Иргэний хамгаалалтын ажлаас

ШТАБЫН ДЭРГЭДЭХ ХЭСЭГ

Дундговь аймгийн ИХШ сумдын иргэний хамгаалалтын штабын дэргэд бэлтгэл офицер, төрөл бүрийн мэргэжлийн сэхээтэн хүмүүсээр бүрдсэн идэвхтний хэсэг байгуулжээ.

Энэ хэсгүүд нь жил улирлын тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж лекц ярианы сэдэв боловсруулж унших, иргэний хамгаалалтын ажлыг шалгаж туслах, зөвлөлгөө өгөх зэргээр ажилладаг аж.

Мөн хүмүүсийн иргэний хамгаалалтын мэдлэг чадварыг дээшлүүлэхийн тулд иргэний хамгаалалтын сурах бичиг, ном товхимол унших хуваарь жагсаалт гаргаж судлуулан шалгалт шүүлэг авч дүгнэдэг байна.

Аймгийн иргэний хамгаалалтын штаб, ХЗЭ-ийн хороо, ҮЭ-ийн Зөвлөлтэй

хамтран иргэний хамгаалалтын сургалт, сурталчлах ажлын талаар нэгдсэн төлөвлөгөөтэй ажиллаж албан даалгавар тогтоол, шийдвэр гаргаж гүйцэтгэлийг нэгдэн шалгаж зааварлах, ХЗЭ-ийн анхан шатны үүр, хороод бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх төв хөдөөгийн ухуулагчдад айл өрх хүн амд иргэний хамгаалалтын талаар ухуулгаа яриа хийхэд нь тусламж болгож гарын авлага материал боловсруулж гаргах, холбогдох семинар зөвлөлгөө өгч ажилладаг аж.

Дундговь аймгийн ИХ-ын эдгээр туршлагыг тус аймгийн нам, эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд, эрдэм дэлгэрүүлэх зэрэг олон нийтийн байгууллагууд ажилдаа тусган авч ажиллах явдал чухал юм.

Р. ЛҮЙЖИР

ХАА-Н МАТЕРИАЛЛАГ УРАМШИЛ

ХАА-н нэгдэл, САА-д 5 жилийн хөдлөхгүй төлөвлөгөөг өгч, үхэр, хонь, ямааны мах, бүх төрлийн ноос, ноолуур, хөөвөр, хялгасыг улсын төвлөрсөн бэлтгэлд нийлүүлэх төлөвлөгөөг бүрэн биелүүлбэл төлөвлөгөөт бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийн дүнгээс 10 хувиар, төлөвлөгөөнөөс давуулан биелүүлбэл давуулж тушаасан бүтээгдэхүүнд бэлтгэлийн үндсэн үнийн 50 хувиар урамшлын нэмэгдэл олгох журам тогтсон билээ.

Манай аймгийн ХАА-н нэгдлүүдэд 1973 онд 1 сая гаруй төгрөгийн нэмэгдэл олгогдсон дотор Эрдэнэсант, Өндөрширээт сум нэгдлүүд 177—178 мянган төгрөгийн нэмэгдлийг авсан байна.

Малын хашааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх аричлгаа эзэмшлийг сайжруулах сонирхолтой холбоон 1970 оноос нэгдэлд улсаас хашаанд олгосон зээлийг болзол хангасан хашаа тутамд 50 хувиар, зохих нөхцөл шаардлагыг бүрэн биелүүлээгүй байвал уг хашаанд авсан зээлийг 30 хувиар хөнгөлөлт үзүүлэх болсон юм. Улсын төвлөрсөн хэрэгцээний малын туувын замд олсон тарга хүчний нэмэгдлээс худалдаа бэлтгэлийн байгууллагад хавар намрын тарга хүчний зөрүүгээс орж байсан ашгийн зарим хэсгийг нэгдэл, САА-д бэлтгэлд тушаасан малын тоо жингийн харьцаагаар бодож шууд хуваарилах болсон билээ. Дээр дурдсан эдийн засгийн урамшлага гадна сүүлийн жилүүдэд улсын бэлтгэлийн мах, сүү, бүх төрлийн ноос, ноолуур, хөөвөр хялгасын үнийг нэмэгдүүлсэн явдал нэгдэл, САА-нуудын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөж ашиг хуримтлалыг нэмэгдүүлэх боломжийг бий болгосон байна. Үүнээс гадна удирдах ажилтан, мэргэжилтэй боловсон хүчний материаллаг урамшлыг өрнүүлэх, үр бүтээлтэй ажиллахад бүх бололцоогоор хангаж, ажлын үр дүнгээр нь цалин хөлсийг нэмж, нэмэгдэл хөлс шагналын журмыг боловс-

руулан мөрдүүлж байна. Сангийн аж ахуйн цалин хөлсийн болзолт урамшлын систем нь тариалан, мал аж ахуйн ажилчдын хөдөлмөрийн хөлсийг жинхэнэ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээтэй холбон олгогдоорой онцлогтой.

Үүгээр нэмэгдэл хөлсийг ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөшүүрэг болгосон байна.

Нэмэгдэл хөлсийг болзолт урамшлын системд газар тариаланд тарифт цалингийн 25 хувь, мал аж ахуйд 15 хувиар тогтоож олгодог.

Мөн тракторч, комбайнчдад тариа хураалт, хадлан бэлтгэх ажил эхэлснээс хойш календарийн эхний 20 хоногт ажлын нэгжид тогтоосон үнэлгээг тариа ногоо төмс хураалтын ажилд 50 хувь, хадлан тэжээл бэлтгэх ажилд 30 хувиар нэмэгдүүлж олгодог.

Тэрчилэн уринш хагалах төлөвлөгөөг 7 дугаар сарын 1-ний дотор, цэвдэгш хагалааг 10 дугаар сарын 25-ны дотор биелүүлж ажлыг чанартай хийсэн техникчдэд тарифт цалин 20 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгож байна.

Тракторч комбайнчдыг тогтвор суурьшилтай ажиллуулж амьдрал ахуйг нь дээшлүүлэх зорилгоор үндсэн мэргэжил дээрээ 3—5 жил ажилласан тракторч комбайнчдад 10 хувь, 5—10 жил ажилласадад 15 хувь, 10-аас дээш жил ажилласан бол 20 хувийн нэмэгдэл олгодог.

Тариа ногоо тариалт, хураалт, уринш, цэвдэгш хагалах, хөрс боловсруулах, хадлан бэлтгэх зэрэг газар тариалангийн ажлыг агротехникийн шаардлагын дагуу техникийн хүчин чадлаар тогтоогдсон хугацаанд ээлжийн нормоо биелүүлсэн өдөр тутамд 6 төгрөгийн нэмэгдэл олгох болсон юм.

Эдгээр нэмэгдэл шагналд САА, ТАА-нуудын хэмжээгээр 1973 онд 839,4 мянган төгрөг олгож урьд жилийнхээс 171,0 мянган төгрөг буюу 25,6 хувиар нэмэгдэж, тракторч комбайнчдын жилийн цалингийн 28,3 хувийг эзлэх боллоо.

ХАА-н нэгдлүүдэд малчдын нэмэгдэл хөлсийг 1972 оноос эхлэн нэгдсэн журамтай болгов.

Нэгдлийн малчдад суурийн үйлдвэрлэлийн даалгавар биелүүлсэн, 100 эхээс бойжуулах төлийг тогтоосон хэмжээнээс илүү бойжуулсан, малдаа сайн тарга хүч авахуулсан болон малын тоо толгойн хамгаалалт зэрэгт нэмэгдэл хөлсийг олгож байна. Малын ашиг шим, ургамлын ургацыг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулахад идэвх материаллаг сонирхлыг дээшлүүлэх зорилгоор САА-д бүтээгдэхүүн үйлдвэрлэх борлуулх төлөвлөгөөг давуулбал давуулан хувь тутамд ажилтныг жилийн цалингийн фондын 1,5 хувиар нэмэгдэл, нэгдэлд сарын цалингийн 3—10 хувиар шагналыг жил бүр олгодог. Материаллаг урамшлын дээрхи хэлбэрүүдээр ХАА-д ажиллагсад жилдээ 3227,1 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс шагналыг олгожээ.

МАХН-аас ХАА-н нэгдэл, САА-н үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг сайжруулах, хөдөлмөрчдийн материаллаг аж байдал соёлын хэмжээг дээшлүүлэхэд байнгын анхаарал халамж үзүүлдгийн нэг тод илрэл нь ХАА-н нэгдлийн цэцэрлэг, ясли, сурагчдын дотуур байрны зардлыг 1973 оны сүүлийн хагас жилээс эхлэн улсын төсвөөр санхүүжүүлэх болсон явдал юм.

Түүнчлэн 8 сая төгрөгийн банкны богино хугацаатай зээлийг төлбөрөөс чөлөөлж, 3 сая төгрөгийн уртын зээлийг хүүгүйгээр 1980 он хүртэл хугацаа сунгаж, ХАА-н нэгдлүүдэд хөрөнгө санхүүгийн тусалцааг улсаас үзүүлсэн байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд нэгдлүүдийн мөнгөн орлого 1971 оныхоос 3,8 сая төгрөг буюу 10,8 хувиар, САА-н борлуулалтын орлого 28 сая төгрөгөөр нэмэгдэж, нэгдлүүд мөнгөн орлогынхоо төлөвлөгөөг 1973 онд



ЗУРАГ ДЭЭР: Грузийн Натанеби Махарадзевийн районы Лениний нэрэмжит хамтралын цай таригч залуучуудын салааны ахлагч, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн депутат С. Л. Николашвили хамтралынхаа ахмад зүтгэлтэн, сонгогчидтойгоо ажил төрлөө зөвлөж байгаа нь.

ТАСС-ын гэрэл зураг

Цай уух зуур

ЗХУ бол барилга байгууламтын хүчирхэг гүрэн юм. Зөвхөн Зөвлөлт засгийн жилүүдэд 4250 шахам шинэ хот, хот маягийн сууринг байгуулжээ. Өнгөрсөн таван жилд хагас миллиард хэвтгэй дөрвөлжин метр талбай бүхий орон сууц барсан нь тус бүр 1 сая хүн амтай 50 гаруй хот барьж байгуулсантай тэнцэх хэмжээ юм.

Сүүлийн 10 жилд Зөвлөлийн хүн амын 42 хувь нь буюу 190 гаруй сая иргэд шинэ сууцны түлхүүр хүлээн авчээ.

Зөвлөлт засгийн жилүүдэд 1250 дунд сургууль, сургуулийн насны хүүхдийн 3000 гаруй байгууллага, 100 илүү кино театр, 57 мянган ор бүхий эмнэлгийн шинэ байшин, олон мянган шинэ дэлгүүр, гуанз ашиглалтанд оржээ.

Эдүгээ шинээр барих барилгын 95 хувийг 9 ба 100,8 хувиар биелүүлсэн байна.

Энэ ололт амжилтаа цаашид улам бататгаж, үйлдвэрлэлийн дотоод дөөц бололцоог дайчлан түүний үр дүнг сайтар төлөвлөн тооцоолж үйлдвэрлэлийн эцсийн үр дүн-

түүнээс дээш 12 хүртэл давхар байхаар төлөвлөн барьж байна.

Ойрын ирээдүйд Москва хот тус бүр 1 сая гаруй хүнтэй 8 том бүсээс бүрдэх болно.

Хот томохын зэрэгцээ бүх төрлийн замыг улам хурдацтай хөгжүүлэх шаардлагатай.

Одоо хотын тээврээр өдөрт 14 сая хүн зорчин байгаагийн 5,5 сая гаруй нь метрогоор явж байна.

Иймээс ордон маягийн хэдэн арван өрөөтэй 200 км урт метро баригдана.

Москва хотын бүх талбайн гуравны нэг хувьд мод тарьж зүлэгжүүлсэн нь их хотыг улам ч гоо сайхан, хүн амын нэрүүл энх амьдрах үлэмж таатай нөхцөлийг бий болгожээ.

Мөн агаар мандлыг бохирдуулж байсан 300 шахам үйлдвэрийг сүүлийн 10 жилд нийслэлийн хүрээнээс гадагш зөөж, заримыг нь шинэчлэн засварласан байна.

ХАА-н үйлдвэрлэлд хүндрэл учруулж болзошгүй цаг агаарын онц аюултай нөхцөл ажиглагдахгүй боловч үе үеийн почир хүйтрэлд хүнсний ногоо гэмтэх, тариа цасанд даврагдах зэрэг тохиромжгүй байдалд орж болзошгүй учир анхаарч ажиллах нь зүйтэй.

Эдийн засагч Ц. ГАНТУЛГА

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б. ЦЭРЭНДАШ



Сарын дундаж агаарын температур 7—10 градус, дулаан хэвийн хэмжээнд. Шөнөдөө сар шинийн эхээр 3—8 градус дулаан, сар шинийн эхэн ба эцсээр сэрүүсч 4 градус дулаанаас 1 градус

Есдүгээр сард

хүйтэн байх ба почир хүйтрэнэ. Цаашдаа сар дуустал 0—5 градус хүйтэн байх ба 17—22-ны үед дулаарч 1—6 градус дулаан, сар хуучийн эцсээр 5—10 градус хүйтэн байна. Өдөртөө сарын хуучийг хүртэл 10—20 градус дулаан байх боловч 15—12-ны үед сэрүүсч 5—10 гра-

дус, сар шинийн эхээр ба 2 дугаар арав хоногийн эцсээр 10—15 градус дулаан, сар хуучдаар 11—16 градус, сар хуучийн дундуур сэрүүсч 4—9 градус дулаан байна. Сар шинэ дээр солигдмол үүлтэй.

Ихэнх өдрүүдэд зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай.

Хоёрдугаар арав хоногийн эхээр үе үе бороо,

сар хуучийн дундуур нойтон цас орно. Салхи баруун хойноос секундэд 3—7 метр байх ба сар шинийн эхэн эцсээр, сар хуучийн дундуур салхи секундэд 10—12 метр хүртэл ширүүснэ.

9 дүгээр сард бүх нутгаар хэвийн хэмжээний орчим буюу төвийн нутгаар 7—10 градус дулаан байна. Дээр дурдсанаас үзвэл 9 дүгээр сард

ХАА-н үйлдвэрлэлд хүндрэл учруулж болзошгүй цаг агаарын онц аюултай нөхцөл ажиглагдахгүй боловч үе үеийн почир хүйтрэлд хүнсний ногоо гэмтэх, тариа цасанд даврагдах зэрэг тохиромжгүй байдалд орж болзошгүй учир анхаарч ажиллах нь зүйтэй.

УС, ЦАГ УУРЫН ТОВЧОО